

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын баталсан 29/01 тоот дотоод аудитын ажлын удирдамжийн дагуу Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын зорилго:

Төгрөг сумын ЗДТГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар хөтлөгдсөн эсэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудалд зөвлөгөө өгөх зорилготой.

Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Төгрөг сумын ЗДТГазрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитаас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт өгөгдсөн тул санхүүгийн тайлагналын хэсгийг хамруулахгүй.

АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Сумын Засаг даргын Тамгын газар гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийхдээ төсөв санхүүтэй уялдуулдаггүй.
Зөвлөмж: 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийж батлуулахдаа батлагдсан төсөвтэйгөө уялдуулан арга хэмжээ бүрт шаардагдах хөрөнгийн хэмжээг тусган сумын Засаг даргаар батлуулж хэвших 2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд арга хэмжээ бүрд зарцуулсан хөрөнгийг тусгаж байх 3. Төсөв хөрөнгө хүрэлцэхгүй байгаа болон хэрэгжүүлэхэд хөрөнгө байхгүй арга хэмжээг дараа онд хэрэгжүүлэхээр хойшлуулах зэргээр зохицуулалтыг хийж, тайландаа тусган ажиллах	
Илэрсэн асуудал 2	Эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй
Зөвлөмж: 1. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох 2. Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх 3. Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах 4. Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх	

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

5. Тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах
6. Эрсдэлийн удирдлагыг гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгэн хэсэг болгон тайлагнах
7. Удирдлагыг эрсдэлийн удирдлагын мэдээллээр хангах
8. Нэгээс доошгүй албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах
9. Байгууллагын эрсдлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх

Илэрсэн асуудал 3

Дотоод хяналтын нэгж төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаггүй.

Зөвлөмж:

1. Дотоод хяналтын журмыг өөрийн онцлогт тохируулан боловсруулж мөрдөх
2. Журманд байгууллагын ямар үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай талаар тусгаж, дотоод хяналтын нэгж үр ашигтай ажилласан байвал хуулийн хүрээнд шагнаж урамшуулах хөшүүргийг бий болгох
3. Байгууллагын дотоод хяналтын зураглалтай болж хамт олноороо мөрддөг байх
4. Дотоод хяналтын нэгжийн 1-ээс доошгүй гишүүнийг Дотоод аудитын мэргэшүүлэх сургалтанд хамруулах
5. Байгууллагын эрсдлийг үнэлэн, дотоод аудитын ажлын төлөвлөгөө гаргахдаа хамгийн их эрсдэлтэй асуудалруу чиглэх

Илэрсэн асуудал 4

НБББББичиг боловсруулаагүй

Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулахын тулд мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөө, сургалт авах
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулан баталж, мөрдөж ажиллах.

Илэрсэн асуудал 5

Хуульд заагаагүй нэмэгдэл цалин олгосон.

Зөвлөмж:

1. Захирамж, тушаал шийдвэрийг төлөвлөн гаргахдаа хууль эрх зүйн мэргэжилтнээр тогтмол хянуулж байх
2. Санхүүгийн ажилтан сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нартаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
3. Цалин хөлс, төсөв хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг гаргахдаа хууль тогтоомжийг үндэслэхэд эргэлзээтэй асуудал гарахад мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөө авч ажиллах
4. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үүргээ гүйцэтгэж байхад нэмэгдэл олгохоор шийдвэр гаргадаг үйл ажиллагааг таслан зогсоох, дахин ийм буруу шийдвэр гаргахгүй байх
5. Бүтэц орон тоонд батлагдсан эзгүй байгаа албан хаагчийн ажил үүргийг орлон гүйцэтгэж байгаа үед нэмэгдэл олгох, харин батлагдаагүй орон тооны буюу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Худалдан авах ажиллагаа, Орон нутгийн

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

хөгжил сан гэсэн ажил үүргийг гүйцэтгэхэд хавсран ажилласаны болон бусад нэмэгдлүүдийг сар бүр тогтмол олгохоор хууль бус шийдвэрийг дахин гаргахгүй байх авч байгаа нэмэгдлүүдийг зогсоох.

**Илэрсэн
асуудал 6**

Захирамж шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн урамшуулал олгосон.

Зөвлөмж:

1. Хууль эрх зүйн ажилтаны ажлын хариуцлагыг дээшлүүлэх
2. Байгууллагын дотоод хяналтын нэгж цалин хөлс олголтод хяналт тавихдаа холбогдох захирамж, тушаалын үндэслэлийг хянах
3. Үр дүнгийн урамшууллыг олгохдоо эрх бүхий албан тушаалтаны захирамжын дагуу олгож байх